

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЕС ДЭХ УДААГИЙН СОНГУУЛИАР БАЙГУУЛАГДСАН  
УЛСЫН ИХ ХУРЛЫН АНХДУГААР ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА

2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2 - 4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5 - 10
1. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал	5 - 7
2. Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал	7 - 10

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн  
анхдугаар чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны  
2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 20 гишүүн хүрэлцэн ирж, 80.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 36 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Ж.Батсуурь, Э.Одбаяр;*

***Нэг. Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хурлын гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд ирүүлснийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар шинээр суурилуулсан тоног төхөөрөмж, программ хангамж хангалттай ажиллахгүй байгаа учраас “санал хураалтыг гар өргөж явуулья” гэсэн горимын саналыг гаргав.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16

Татгалзсан: 4

Бүгд: 20

80.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Л.Энх-Амгалан:** Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 1

Бүгд: 20

95.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Хоёр. Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Х.Тэмүүжин нар үг хэлэв.

**Л.Энх-Амгалан:** Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, Б.Чойжилсүрэн, Л.Энх-Амгалан, Ж.Энхбаяр, Ж.Бат-Эрдэнэ, Н.Алтанхуяг, Х.Баттулга, Л.Гантөмөр нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16  
Татгалзсан: 4  
Бүгд: 20  
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 17 минут үргэлжилж, 25 гишүүнээс 23 гишүүн хүрэлцэн ирж, 92.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 53 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН

Л.ЭНХ-АМГАЛАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,  
Баасан гараг  
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
14 цаг 36 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Л.Энх-Амгалан:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амрыг айлтгая.

Байнгын хороонд ирвэл зохих 25 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 72.2 хувьтай ирц бүрдсэн учраас 2024 оны 07 сарын 05-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр хоёр асуудал байгаа.

Нэгд нь, Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох.

Хоёрт нь, Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал.

Ийм хоёр асуудал байгаа юм байна.

Хэлэлцэж байгаа хоёр асуудалтай холбогдож саналтай гишүүн байна уу? Алга байна.

### Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай асуудал

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох тухай саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар танилцуулна.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга,

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр Улсын Их Хуралд олонхын суудал авсан Монгол Ардын намаас Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдад нэр дэвшүүлэн 07 дугаар сарын

05-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүллээ.

Монгол Улсын үндсэн хуулийн 39.2 дахь хэсэгт Улсын Их Хуралд олонх суудал авсан намын хэлтсээс нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна гэж заасны дагуу Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд танилцуулж байна.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ нь 1980 онд Улаанбаатар хотод төрсөн, 44 настай, эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг.

Тэрээр 2001 онд “Бэрс” дээд сургуулийг сэтгүүлч, 2008 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч, 2011 онд Монгол Улсын Их Сургуулийн Улс төр, нийгмийн шинжлэх ухааны сургуулийг улс төр судлаач мэргэжлээр тус тус төгсөж, 2015 онд Америкийн Нэгдсэн Улсын Харвард Кеннедийн их сургуульд төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалжээ.

2001 онд Хэнтий аймгийн Бэрх хотын Захирагчийн албан Тамгын газрын дарга, 2002-2008 онд Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн удирдагч, бүсийн захирал, 2008 онд Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, 2009 онд Монгол Ардын намын Удирдах зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга, 2010-2014 онд Нийгмийн Ардчилал Монголын залуучууды холбооны Ерөнхийлөгч, 2011 онд Монгол Ардын намын нарийн бичгийн дарга, 2012 онд Монгол Ардын намын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, 2016 оноос одоог хүртэл Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2019 оноос Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, 2021 оноос Монгол Улсын Ерөнхий сайдаар ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулахаар санал болгосон Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийн асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Л.Энх-Амгалан:** Г.Занданшатар даргад баярлалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болон нэр дэвшигчээс асуух

асуулттай гишүүд байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүд алга байна.

Одоо санал хураалт. Шинэ төхөөрөмж учраас эхлээд төстийн санал хураалтаа хийчхээд тэгээд дараа нь санал хураалтаа хийе. Тэгэх үү? Гар өргөчих үү?

Тэгвэл нэг нь зарчмын зөрүүтэй саналын томьёолол. Горимдоно шүү дээ. Л.Мөнхбаатар дарга горимдох уу? Тэгэх үү?

Л.Мөнхбаатар гишүүний микрофоныг.

**Л.Мөнхбаатар:** Горимын санал гаргая.

Энэ төхөөрөмжүүд маань шинээр ирсэн. Программчлал болоод бусад зүйлээр тодорхой алдаа гараад байгаа учраас гар өргөж явуулах горимын санал гаргаж байна.

**Л.Энх-Амгалан:** Л.Мөнхбаатар даргын горимын саналыг дэмжье гэсэн нь.

Олонх нь байна. Горимын санал дэмжигдсэн учраас саналыг гар өргөж санал хураалт хийнэ.

Санал хураалт.

Лувсаннамсрайн Оюун-Эрдэнийг Монгол Улсын Ерөнхий сайдаар томилуулах тухай саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураая.

20-оос 18.

Татгалзаж байгаа хүн байна уу? Нэг гишүүн татгалзаж байгаа юм байна.

Ингээд Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай саналыг хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан танилцуулна.

Дараагийн асуудалд орёе.

Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдсон Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдад ажлын амжилт хүсье. /алга ташив/

Байнгын хорооны саналаар дэмжигдсэнд.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Г.Занданшатар даргад бас баярлалаа.

Хоёр дахь асуудал руугаа орёе.

### Хоёр. Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудал

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27.8-д Монгол Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороо Улсын Их Хуралд хамгийн олон удаа сонгогдсон 9 гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд цөөнхийн төлөөллөөс оруулна.

Гишүүдийн сонгогдсон тоо адил байгаа тохиолдолд тэдгээрийн харьяалагдах нам, эвслийн бүлгийн саналыг баримтална гэсэн зохицуулалттай юм байна.

Ингээд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороонд

Нэгд нь, Монгол Ардын намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт Улсын Их Хуралд 5 удаа сонгогдсон.

Хоёрт нь, Монгол Ардын намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн Улсын Их Хуралд 5 удаа сонгогдсон.

Гуравт нь, Монгол Ардын намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэн Улсын Их Хуралд 5 удаа сонгогдсон.

Дөрөвт нь, Монгол Ардын намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан 4 удаа сонгогдсон.

Тавд нь, Монгол Ардын намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаяр Улсын Их Хуралд 4 удаа сонгогдсон.

Зургаад нь, Ардчилсан намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг Улсын Их Хуралд 5 удаа сонгогдсон.



Долоод нь, Ардчилсан намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Халтмаагийн Баттулга Улсын Их Хуралд 4 удаа сонгогдсон.

Найд нь, Ардчилсан намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Лувсанн्याмын Гантөмөр Улсын Их Хуралд 4 удаа сонгогдсон.

Есөд нь, Монгол Ардын намын бүлгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ Улсын Их Хуралд 3 удаа сонгогдсон.

Ийм 9 гишүүнээр халдашгүй байдлын дэд хорооны гишүүд бүрдэж байгаа юм байна.

Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудалтай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд байна уу?

Б.Пүрэвдорж гишүүн.  
Б.Пүрэвдорж гишүүний микрофоныг нээгээрэй.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр мэдээж Халдашгүй байдлын дэд хорооны гишүүнээр бас олон сонгогдсон туршлагатай хүмүүсийг сонгодог уламжлалтай.

Тэгэхээр энэ дээр бас мэдээж 6 хүн 6:3-ын харьцаатай гарч байна л даа.

Тэгэхээр энэ бол ялангуяа сөрөг хүчний асуудал орж ирэхэд тодорхой хэмжээгээр саналыг ойртуулах ийм шаардлага байна.

Тийм учраас 5:4-өөр сонгож, Монгол Ардын намаас 5, Ардчилсан намаас 4 гэдэг ийм байдлаар.

Бид зөвхөн Ардчилсан намын асуудлыг ярихгүй.

Парламент сонгосон бусад намын асуудлыг бас ярилцаж, тэдний эрх ашгийг тодорхой хэмжээгээр хангах ийм үүрэг хүлээнэ.

Тийм учраас 5:4-өөр сонгож өгөөч ээ. Тэгээд санал хураалт явуулаад шийдэж өгөөч ээ гэж хүсэж байна.

Тэгэх юм бол дараа нь дахиад бүрэлдэхүүнийг дахин нэр дуудах шаардлага гарах байх.

**Л.Энх-Амгалан:** Б.Пүрэвдорж гишүүн ийм юм байна.

Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн тухай хуулиар би түрүүн уншсан.

9 гишүүнээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүн цөөнхийн төлөөллөөс оруулна гэсэн ийм л зохицуулалттай.

Түүнээс биш 5:4-өөр, 3:8-аар гэсэн ийм зохицуулалтууд байхгүй.

Гишүүдийн сонгогдсон тоо ижил байгаа тохиолдолд харьяалагдах нам, бүлэг, эвслийн саналыг баримтална гээд.

Хоёр бүлгийн дарга ярилцаад үндсэндээ гишүүдийнхээ нэрсийг тохирчихсон учраас тэгээд одоо яая даа. Тийм ээ.

Хуульд байхгүй саналаар горимын санал хураалгахгүй шүү дээ. Тийм.

Х.Тэмүүжин гишүүн.

**Х.Тэмүүжин:** Ер нь Халдашгүй байдлын дэд хороо гээд ийм нэртэй

парламентын институц өөр бусад улс оронд ч бараг байхгүй шүү дээ.

Өөр бусад улс орнуудад юу ярьж байгаа вэ гэхээр Ёс зүйн дэд хороо гэдэг институц үүсгээд тэндээ ёс зүйн зөрчлийг болон бүрэн эрхээс нь эргүүлэн татах асуудал хоёрыг хоёуланг нь хамтад нь хэлэлцэж байгаа байхгүй юу.

Тэгээд өнгөрсөн парламентад та хэд маань олонх байхдаа Ёс зүйн хариуцлагын байнгын хороо гээд бүр их хүчтэй Байнгын хороо байгуулчихсан юм билээ.

Хэрвээ тийм Байнгын хороо байгуулсан бол тэр Байнгын хорооны чинь нэг том чиг үүрэг нь энэ. Одоо бидний ярьж байгаа энэ асуудал байхгүй юу.

Ёс зүй ярихаараа тусдаа Байнгын хороонд яриад байдаг. Хариуцлага ярих болохоор бүр халдашгүй гэж нэрлэж байгаад хүн гаргахгүй хаалттай гэж гэдэг шиг ингэж юм тавиад тэгээд түүн дотроо юу гэдэг юм хамгийн удаан жил ажилласан. Мэдээж хэрэг олон улсад Ёс зүйн дэд хороон дээр хамгийн олон удаа парламент сонгосон хүмүүс байдаг юм билээ. Гэхдээ илүү өргөн бүрэлдэхүүнтэй байдаг юм билээ. Яг парламентад суудал авсан пропорцоороо ордог юм билээ.

Тэгэхээр бид ер нь ийм. Нэг бол тэнд байгаа Байнгын хороо татан буулгах, эсвэл энд байгаа Халдашгүй байдлын дэд хороогоо татан буулгах гэдэг хоёр сонголт байгаа.

Үнэхээр Байнгын хорооны хэлбэрээр цаашаа явъя гэж бодож байгаа бол та хэд маань бас зориг гаргаад ер нь энэ Халдашгүй байдлын дэд хороогоо татан буулгах нь зөв байх шүү.

Одоогоор Халдашгүй байдлын дэд хороон дотор чинь орсон хүмүүсийг хараад энэ парламент ямар ч байсан энэ ашиг сонирхлын зөрчил, авлига, энэ хариуцлагын асуудал дээр үгүй гэж хэлж байгаа юм шиг уншигдаж байна шүү.

**Л.Энх-Амгалан:** Гишүүд үг хэллээ.

Одоо юу яая даа. Цөмөөрөө. Бас Улсын Их Хурал шинээр бүрдэж байгуулагдаж байгаа учраас одоо ингээд энэ хууль дээрээ бид нар бас энэ шинэ Их Хурал таны гаргасан саналаар бас Их Хурлынхаа тухай хууль, Их Хурлынхаа дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулаад явах нь нээлттэй байгаа шүү дээ. Тийм ээ.

Үг аваад дуусчихсан Б.Батбаатар гишүүн ээ.

Ингээд Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хороог Улсын Их Хурлын гишүүн. Сая нэр уншсан. Тийм ээ.

Энэ гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулахыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт хийе.

Санал хураалтыг ил явж байгаа. Тийм ээ. Тоолчхоорой. Тоолоод юуг нь хэлчхээрэй. Тийм ээ.

Татгалзсан гишүүд байна уу? Тоолчхоорой. Тоолоод ячих.

20-оос 16 гишүүн дэмжсэн учраас энэ асуудал дэмжигдэж, Улсын Их Хурлын халдашгүй байдлын дэд хороо байгуулагдаж байна.

Ингээд Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар дарга танилцуулна.

Ингээд өнөөдрийн төс Төрийн байгуулалтын байнгын хороогоор

хэлэлцэх хоёр асуудлыг хэлэлцэж дууслаа.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.  
/алх цохив/

**Хуралдаан 17 минут үргэлжилж, 14 цаг 53 минутад өндөрлөв.**

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**